

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэврэй сумын цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2022/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn Аудитор: С.Одончимэг Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

СЭВРЭЙ СУМЫН 20 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ч.ЭРДЭНЭЧИМЭГ ТАНАА

2022.02.22 № 85

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Сэврэй сумын 20 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэврэй сумын 20 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

D:\2021 Он\Бичиг Хэрэг\Явсан Бичиг\2022-02-21 №85'с

02022100

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	54.00	49.80
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	819.20	819.00
	Нийт хөрөнгийн дүн	873.20	868.80
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	873.20	868.80
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	873.20	868.80
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	434.80	277.80
	Үйл ажиллагааны зардлын дүн	314.10	280.80
	Үйл ажиллагааны үр дүн	120.70	- 3.00
	Үйл ажиллагааны бус үр дүн		- 1.40
	Үйл ажиллагааны нийт үр дүн	120.70	- 4.40
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	873.20	873.20
	Тайлант оны үр дүн		- 4.40
	Эцсийн үлдэгдэл	873.20	868.80
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	233.30	242.10
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	233.30	242.10
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	236.30	227.30
	Урсгал зардал	236.30	227.30
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	236.30	227.30
	Улсын төсвөөс санхүүжих	204.50	197.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	31.80	30.30
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих		-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сургуулийн өмнөх насны хүүхдэд СӨБ боловсрол олгох, тус байгууллагын багш ажилчдад ажил үүргийг чанартай гүйцэтгүүлэх, чадваржуулах тэдний нийгмийн асуудалд анхааран ажиллах хүүхэд нэг бүрийг хөгжүүлэн зөв монгол иргэнийг төлөвшүүлнэ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал болон алслагдсан суманд очиж ажиллах санхүү, хүний нөөц, цаг хугацааны хувьд боломжгүй байсан тул байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, бараа материал, үндсэн хөрөнгийн биет тооллого хийх, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж байсныг дурдах нь зүйтэй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хүнсний материалын зарлага хийхдээ эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг хэрэглээгүй, он дамжсан 5 нэр төрлийн 0.5 сая төгрөгийн хүнсний үлдэгдэлтэй байгаа нь нягтлан бодох бүртгэл хөтлөлтөө сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд 150 мэдээлэл байршуулахаас 6 мэдээлэл хугацаа хоцруулан байршуулсан, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг оруулаагүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 24.9 сая төгрөгийн худалдан авалтын 7 гүйлгээг өссөн дүнгээр мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 75.3 сая төгрөгийн 4 ажил гүйлгээ, хөрөнгө зарцуулсан 1.6 сая төгрөгийн 1 шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.4.4, 6.4.5, 6.4.8-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар хүүхдийн хоолны цэсийг хүнсний зарлагын тайлантай тулган баталгаажуулах нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 185.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 78.4 сая төгрөгийн алдааг залруулж, 103.8 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 3.0 сая төгрөгийн зөрчилд төсвийн сахилга батыг сайжруулах 5 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	9	82.0	3	78.4			1	0.6	5	3.0
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	1	103.2					1	103.2		
3	Нийт дүн	10	185.2	3	78.4			2	103.8	5	3.0